



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Албаны даргын дэргэдэх зөвлөл
байгуулах тухай

“Төсвийн тухай хуулийн” 16.1, 16.4.5, Албаны “Дотоод журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын санхүү, хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт, дотоод журмын хэрэгжилт, ажилтнуудын үйл ажиллагааны үр дүн, сахилга, хариуцлага, шагнал урамшуулал, ажилтнуудын нийгмийн асуудлыг хангах талаар санал, зөвлөмж боловсруулан гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах “Албаны даргын дэргэдэх зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилон ажилуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: Дэд дарга

Гишүүд: Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга

Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Ахлах мэргэжилтэн

Нягтлан бодогч

Дотоод болон шуурхай ажил хариуцсан мэргэжилтэн

2. Гарсан асуудлыг шуурхай, оновчтой, шударга зарчмыг баримтлан тухай бүрт албаны даргад танилцуулж, тайлагнан ажиллахыг “Албаны даргын дэргэдэх зөвлөл”-д үүрэг болгосугай.

3. Зөвлөлийн ажиллах журмыг 07 сард багтаан боловсруулж, батлуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Ч.Цог/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарч мөрдөгдөх болсонтой холбогдуулан 2013 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн Б/10 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



[Signature] дорч.БАТСАЙХАН